



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН АЛБА
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 07 сарын 31 өдөр

Дугаар СХМ-2024/07

Сүхбаатар сум

Сант сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт
шалгалтын дүн

**Нэг: Хяналт шалгалтын зорилго, хамарсан хүрээ, хугацаа, шалгуулсан
байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалт**

1.1 Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 03 дугаартай “Санхүүгийн хяналтын ажлын удирдамж”-аар Сант сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын санхүү төсвийн гүйцэтгэл болон Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиуд болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн актуудын хэрэгжилтийг хянан шалгах, илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт өгөх засаж залруулах зорилготойгоор хяналт шалгалт хийлээ.

1.2 Шалгалтыг Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны Ахлах дотоод аудитор, Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Т.Мөнхзул, Дотоод аудитор Х.Батбаатар нарын бүрэлдэхүүнтэйгээр 2024 оны 07 дүгээр сарын 22-ны өдрөөс ажлын 15 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

1.3 Шалгалтад Сант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал (цаашид ИТХ гэх)-ын 2024 оны эхний хагас жилийн санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагааны баримт материал, тайлан тооцоог хамруулав.

1.4 Сант сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь улсын бүртгэлийн 3762483 регистртэй, төрийн сан дах үндсэн үйл ажиллагааны 100130654001 данстай.

Санхүү, татварын баримтад 1 дүгээр гарын үсгийг ИТХ-н нарын бичгийн дарга О.Мөнхцэцэг, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Ч.Мөнхзаяа нар зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулж, мэдээ тайлан гаргаж ирсэн байна.

1.5 2023 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 14 дүгээр хуралдаанаар сумын ИТХ-ын ажлын албаны бүтэц орон тоог баталсан байна.

Сумын ИТХ нь хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал, дүгнэлт гаргах, Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг бүхий Нутгийн удирдлага, хууль зүйн хяналтын бодлогын хороо, Хөгжлийн бодлогын хороо, Нийгмийн бодлогын хороо, ХАА, байгаль орчны бодлогын хороо зэрэг Хурлын хороо 4-

г байгуулан ажиллуулж Хурлын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг ханган ажиллаж байна.

1.6 Иргэдийн Төлөөлөгчдийн болон Нийтийн Хурлын ээлжит хуралдааныг улиралд нэг удаа хуралдуулдаг. Тайлант хугацаанд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан 3 удаа, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөл 3 удаа, багийн иргэдийн Нийтийн Хурал тус бүр 1 удаа хуралдуулсан. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн хуралдаан, багийн иргэдийн Нийтийн Хуралдаан, сургалт, бодлогын хороодын хуралдааны бэлтгэл ажлыг хангаж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих зэрэгт ажлын албаны зүгээс голлон анхаарч ажилласан байна.

1.7 Иргэдийн Төлөөлөгчдийн болон Нийтийн Хурлын ээлжит хуралдааныг улиралд нэг удаа хуралдуулдаг. Тайлант хугацаанд ИТХ-ыг 3 удаа, Нийтийн Хурлыг 1 удаа хуралдуулсан. Сумын ИТХ-ын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, Сумын ИТХ-ын төлөөлөгчид болон БИНХ-ын зөвлөлийн гишүүдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх зэрэгт ажлын албаны зүгээс голлон анхаарч ажилласан байна.

Үүнд:

№	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуралдсан огноо	хурлаар		Ирц /Хувь/
		Хэлэлцсэн асуудал	Шийдвэрлэлт (тогтоолын дугаар)	
1	2024.02.28	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хэсэг байгуулах тухай	89	63.2%
2		Сумын ИТХ-ын 2023 оны үйл ажиллагааны тухай	90	
3		Сумын ИТХ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө тайлан хэлэлцэх тухай	91	
4		Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай	92	
5		Сумын ИТХ-ын бүтэц орон тоог шинэчлэн тогтоох тухай	93	
1	2024.04.25	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн сурталчилгааны нэгдсэн болон зурагт самбарыг байршил тогтоох	94	57.9%
2		Сумын ИТХ-ын сонгуулийн тойрог байгуулж, тойрогт ногдох мандатын тоо, дугаар, төвийг тогтоох тухай	95	
3		Дэд зөвлөл байгуулж ажиллах журам батлах тухай	96	
4		Сумын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай	97	
5		Шагналын журам батлах тухай	98	
6		Сумын аварга малчин, аварга фермер шалгаруулах журам батлах тухай	99	
1	2024.05.20	Сонгуулийн хэсэг байгуулах тухай	100	63.2%

2	Зөвлөлийн бүрэлдэхүүн улируулан сонгох тухай	101
3	Тогтоол хүчингүйд тооцох тухай	102
4	Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай	103

Хоёр. Шалгалтад хамрагдах асуудлууд

2.1 Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт

Тус сумын ИТХ нь санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн хууль болон бусад санхүүгийн хууль тогтоомжийн хүрээнд УСНББОУС, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдлөг болгон нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулж байна.

Шилэн дансны тухай хуулийн дагуу цахим системд нийт 87 мэдээлэл байршуулахаас 2024 оны эхний хагас жилийн байдлаар 73 мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн мэдээлжээ хуулийн хэрэгжилтийг 82.8% хангасан байна.

2.2. Батлагдсан төсөв, гүйцэтгэл зориулалтын дагуу зарцуулсан байдал

2.2.1 Батлагдсан төсөв:

2024 онд сумын ИТХ нь хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр батлагдсан төсвийн дагуу орон нутгийн төсвөөс 85387.2 мянган төгрөгийн санхүүжилт авахаас 74034.47 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 74034.47 мянган төгрөгийг зарцуулсан.

2.2.2. 2024 оны үйл ажиллагааны батлагдсан төсөв, гүйцэтгэлийг дараах хүснэгтээр харуулав:

Хүснэгт 1.

(мянган төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2024 оны эхний хагас жил		хэмнэлт/+/ хэтрэлт /-/ Зөрүү
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	
1	Үндсэн цалин	29,276.10	29,600.50	-324.40
2	Нэмэгдэл	25,977.40	21,975.61	4,001.79
4	Урамшуулал	4,725.00	2,436.72	2,288.28
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын дүн	59,978.50	54,012.83	5,965.67
6	Ажил олгогчоос төлөх НД-ын шимтгэл	7,498.70	6,384.85	1,113.85

7	Бичиг хэрэг	540.00	547	-7.00
8	Тээвэр, шатахуун	1,800.00	1,616.86	183.14
9	Шуудан, холбоо, интернэт	360	210	150.00
10	Бага үнэтэй түргэн элэгдэх	0	0	0.00
11	Хангамж бараа материалын зардлын дүн	2,700.00	2,373.86	326.14
12	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0	-	0.00
13	Норматив зардал	0	-	0.00
14	Багаж, техник, хэрэгсэл	1,200.00	579.9	620.10
16	Эд хогшлын зардлын дүн	1,200.00	579.90	620.10
17	Дотоод албан томилолт	1,020.00	371.45	648.55
18	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	683.40	448.00	235.40
19	Аудит, баталгаажуулалт	184.6	0	184.60
20	Тээврийн хэрэгслийн даатгал татвар оношилгоо	0	0	0.00
23	БГАУ, бараа үйлчилгээний бусад зардлын дүн	868.00	448.00	420.00
24	Бараа үйлчилгээний бусад зардал	2,020.00	759.10	1,260.90
25	Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардал	520.00	349.5	170.50
26	Бараа үйлчилгээний бусад зардал	2,540.00	1,108.60	1,431.40
27	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	9,582.00	8,754.98	827.02
28	Урсгал шилжүүлгийн дүн	9,582.00	8,754.98	827.02
НИЙТ ЗАРДЛЫН ДҮН		85,387.20	74,034.47	11,352.73

- 1. Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал:** 2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт төсвийн гүйцэтгэл 90.1% -тай байна. Үндсэн цалингийн зардлыг 324.4 мянган төгрөгөөр хэтрүүлсэн бол, нэмэгдэл цалин 4,001.79 мянган төгрөг, урамшуулал 2,288.28 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.
- 2. ЭМНДШ-ийн зардал:** Ажил олгогчоос 10%-12.5%-аар тооцон ажилтны төлсөн шимтгэлийн хамт нийгмийн даатгалын байгууллагад шилжүүлж, сар бүр НД 8 маягтаар тайлагнасан байна.
- 3. Хангамж бараа материалын зардал:** 2024 онд бараа материалын зардалд 2,700.00 мянган төгрөг батлагдаж 2,373.86 мянган төгрөгийг зарцуулжээ. Бараа материалыг бүртгэлд тусгахдаа худалдаж авсан тухай бүр орлого авч бүртгэн шаардахын дагуу зарлагаддаг. Албаны хэрэгцээнд байнга хэрэглэгдэх аж ахуйн чанартай хөрөнгийг орлогод бүртгээд шууд зарлагадсан байна. Шатахууны зарцуулалтыг шаардах хуудас, маршрутыг үндэслэн зарлагадаж бүртгэсэн байна.

4. **Томилолтын зардал:** 2024 онд 1020.00 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас эхний хагас жилийн байдлаар 371.45 мянган төгрөгийн зарцуулж тайлагнасан байна.
5. **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж:** 2024 онд 683.40 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас эхний хагас жилийн байдлаар 448.00 мянган төгрөг зарцуулсан.
6. **Бусад зардалд:** 2024 онд 2,540.00 мянган төгрөг батлагдсанаас эхний хагас жилийн байдлаар бараа үйлчилгээний бусад зардалд 759.10 мянган төгрөгийг, хичээл үйлдвэрлэлийн зардалд 349.5 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.
7. **Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал:** 2024 онд сумдад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдад таван жил ажилласны мөнгөн урамшуулал олгох 9.582.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 8,754.98 мянган төгрөг зарцуулсан.

ИТХ-ын 14 дүгээр хуралдааны хоолны зардал 349.5 мянган төгрөгийг Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас, шагналын зардал 342.0 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас, ИТХ-ын архивын дарсан худалдан авах 132.0 төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжаас, нийт 823.5 мянган төгрөгийг эдийн засгийн ангилал буруу зарцуулсан байна.

2.3. Санхүүгийн үйл ажиллагааны явц, өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, нягтлан бодох бүртгэл хөтлөлт

Үндсэн хөрөнгө: ИТХ нь 2024 оны эхэнд тоног төхөөрөмж 8,978.0 мянган төгрөг, тавилга эд хогшил 4,189.0 мянган төгрөг, бусад үндсэн хөрөнгө 519.0 мянган төгрөгийн нийт 13,386.0 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй, тайлант онд 529.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг төсвийн хөрөнгөөр бий болгож 14,215.9 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Дээрх хөрөнгийг санхүүгийн тайлан бүртгэлд тусгасан байна.

Үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийг Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 5.4-т заасан “Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа”-тай тулган баталгаажуулахыг зөвлөв.

Бараа материал: 2024 онд 40.0 мянган төгрөгийн бараа материалын эхний үлдэгдэлтэй төсвийн хөрөнгөөр 2,613.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч зарцуулан эхний хагас жилийн байдлаар 40.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна. Албаны хэрэгцээнд байнга хэрэглэгдэх аж ахуйн чанартай 182.5 мянган төгрөгийн хөрөнгийг орлогод бүртгээд шууд зарлагдсан байна.

Тайлант хугацаанд ГХУСС зөвлөлийн зардалд 415.1 мянган төгрөг, шатахууны зардалд 1,616.8 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 547.0 мянган төгрөг, шуудан

холбооны зардалд 210.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан баримтаар нотлогдож байна.

Өмч хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 2.

(мянган төгрөгөөр)

№	Хөрөнгийн хөдлөлийн утга	Орлого зарлагын гүйлгээний утга	Өмч хөрөнгө:	
			Үндсэн хөрөнгө	Бараа материал
1	Оны эхний үлдэгдэл		13,686.0	40.0
2	Төсвийн эх үүсвэрээр	худалдан авсан	529.9	2,613.46
3	Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэс	шилжүүлэн авсан		
4	Бусад /дахин үнэлсэн/	шилжүүлэн авсан		
5	Бусад			
6	Орлогын дүн		529.9	2,613.46
7	Үйл ажиллагаанд зарцуулсан	анхан шатны баримт		2,613.46
8	Байгууллагуудад шилжүүлсэн	шилжүүлсэн		
9	Акталж данснаас хассан	тушаалаар		
10	Зарлагын гүйлгээний дүн			2,613.46
11	Оны эцсийн үлдэгдэл		14,215.9	40.0

2.4 Ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцоолт, олголтын байдал

2024 оны эхний хагас жилийн байдлаар сумын ИТХ-ын ажлын албаны цалинг 2 удаа шинэчлэн баталсан байна.

2024 онд сумын ИТХ-ын ажлын албанд ажиллагсдын орон тоо, цалин хөлс, нэмэгдэл, ажил олгогчоос төлөх НДШ-ийн батлагдсан төсөв, гүйцэтгэл хийсэн дүн шинжилгээ хийлээ:

Хүснэгт 3.

(мянган төгрөгөөр)

№	Үзүүлэлт	ИТХ		БИНХ	
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл
1	Үндсэн цалин	29,276.10	29,600.50	0	3,948.8
2	Нэмэгдэл цалин	25,977.40	21,975.61	0	0
3	Урамшуулал	4,725.00	2,436.72	4,725.0	767.57
5	Цалин хөлс нэмэгдэл дүн	59,978.50	54,012.83	4,725.0	4,716.37
5	Ажил олгогчоос төлөх НДШ	7,498.70	6,384.85	591.5	489.94

Цалин хөлс НДШ-тэй холбоотой нийт зардлын дүн	67,477.20	60,397.68	5,316.5	5,206.31
Орон тооны мэдээлэл	3	3	2	2

Сумын ИТХ нь 3, багийн иргэдийн нийтийн хурал 2, нийт 5 орон тоотойгоор үйл ажиллагааг явуулж цалин хөлс, нэмэгдэл, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 72,793.7 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 65,603.99 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Ажиллагсдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдлыг хяналт шалгалтын явцад цалингийн дэлгэрэнгүй цэсээс хүн тус бүрийн албан тушаалын ангилал, зэрэглэл, батлагдсан цагийн тооцоо, нэмэгдэл суутгал, тооцох тушаал шийдвэртэй тулган баталгаажуулахын зэрэгцээ НДШ-ийн дэлгэрэнгүй НД8 тайлантай нэг бүрчлэн тулган шалгахад авлага үүсгээгүй байна.

2.5 Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт

Тус сумын ИТХ нь 2024 онд төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх томоохон худалдан авалт байхгүй байна.

Сумын ИТХ нь 2024 онд төсвийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил үйлчилгээний 132.0 мянган төгрөгийн гэрээг 1 аж ахуй нэгж байгууллагатай гэрээг байгуулан 3 ширхэг архивын дардас худалдан авсан байна.

2.6. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайланд хяналт тавих

1. Анхан шатны баримтын бүрдэл

- Бараа материалын худалдан авалт, анхан шатны баримтын иж бүрдлийг тулган шалгахад тайлант хугацаанд иргэн Санжжав овогтой Оюунбаяраас нийт 118.5 мянган төгрөгийн худалдан авсан бараа, ажил гүйлгээний нэхэмжлэх, и-баримт нь бөөн дүнгээр бүртгэгдсэн байна.

2. Шатахуун зарцуулалт

НИК ХХК-тай гэрээ байгуулж, шатахууны дараа төлбөрт кредит карт ашиглан эхний хагас жилийн байдлаар 1,616.8 мянган төгрөгийг зарцуулсан байна. Анхан шатны баримтын бүрдлийг тулган шалгахад:

- Жолоочийн тооцооны хуудас бүрэн хөтөлсөн боловч автомашины 100 км-д зарцуулах шатахууны нормыг нэг автомашин дээр өөр өөрөөр тооцон олгосон байна.
- Зарцуулсан шатахууны анхан шатны баримтын бүрдэл дутуу

3. ИТХ хуралдааны зардал

Сумын ИТХ-ын төлөөлөгчдийн хуралдааны хоол, цайны зардалд 2 аж ахуйн нэгж байгууллагад 349.5 мянган төгрөг шилжүүлсэн байна.

ИТХ-ын хуралдааны хоол, цайны зардлыг эдийн засгийн ангилал буруу зарцуулсан байна.

2.7 Өмнөх шалгалтын талаар

Хүснэгт 6.

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн шийдвэрлэлт	2023 он				
	Үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	хувь
Зөвлөмж акт	1	0	1	100	100.0
Нийт дүн	1	0	1	100	100.0

Төрийн аудитын байгууллагаас хийсэн хөндлөнгийн хяналт шалгалтаар 2023 онд “Тайлант онд татварын хөнгөлөлтийн тооцооллыг хийгээгүй нь ХХОАТ-ын авлага үүсгэх эрсдэл үүсгэсэн байна” гэсэн зөвлөмжийн дагуу 2024 оны эхний хагас жилийн тайланд үнэн зөв тусгаж давтан гаргахгүй байхад анхааран ажиллаж байна.

Гурав. Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн зөрчил дутагдал

Сант сумын ИТХ-ын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар журнал хөтлөлт, шилэн дансны цахим хуудасны хөтлөлтөөр хангалттай сайн, төсөв, санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангасан зэрэг ололт бүхий нөхцөл байдал тогтоогдсон бол хууль тогтоомжийн хэрэгжилт, санхүүгийн бүртгэл хөтлөлтийн анхан шатны баримтын бүрдүүлэлт хангаагүй дараах зөрчил, дутагдал илэрсэн. Үүнд:

Төсвийн шууд захирагчийн эрхлэх асуудалтай холбоотой зөрчил дутагдал:

Илрүүлэлт 1. Анхан шатны баримтын бүрдэл дутуу /Жолоочийн тооцооны хуудсыг буруу бөглөсөн, автомашины тээврийн хэрэгслийн гэрчилгээ, жолоочийн үнэмлэхийн хуулбар байхгүй/

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”

Илрүүлэлт 2. Шатахууны нормыг Зам, тээврийн сайдын баталсан нормын дагуу тооцоогүй /Нэг тээврийн хэрэгсэл дээр нормыг өөр өөрөөр тооцож олгосон./

Энэ нь Зам тээврийн хөгжлийн сайдын "Жишиг норм батлах тухай" 2019 оны 390 дугаар тушаалаар батлагдсан "Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм" нэгдүгээр хавсралттай нийцэхгүй байна.

Илрүүлэлт 3. 823.5 мянган төгрөгийн зардлыг бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.2 дахь “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага

гаргах”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Эдийн засгийн ангилал ашиглах заавар"

Илрүүлэлт 4. Албаны хэрэгцээнд байнга хэрэглэгдэх аж ахуйн чанартай хөрөнгийг орлогод бүртгэн аваад шууд зарлагадсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна.”

Илрүүлэлт 5. Төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил гүйлгээний цахим төлбөрийн баримтыг бөөн дүнгээр бүртгэсэн 118.5 мянган төгрөгийн худалдан авалт байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Дөрөв. Дүгнэлт, шийдвэрлэлт:

4.1 Дүгнэлт:

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан удирдамжаар Сант сумын ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан 2024 оны эхний хагас жилийн санхүү, төсөв, бүртгэлийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр “Бага” эрсдэлтэйд тооцож, төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн, сумын ИТХ-ын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагааны горимыг баримталж ажилласан байна гэж дүгнэлээ.

4.2 Шийдвэрлэлт:

Сант сумын ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар нийт 2,912.6 мянган төгрөгийн 5 зөрчил илэрснээс санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн хугацаатай 2,612.1 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлэх, төсвийн хөрөнгөөр худалдан авсан албаны хэрэгцээнд байнга хэрэглэгдэх аж ахуйн чанартай хөрөнгийг орлогод бүртгэж шууд зарлагадахгүй байх, Зам тээврийн сайдын баталсан “Жишиг норм батлах тухай” 2019 оны 390 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган ажиллах, төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил гүйлгээний цахим төлбөрийн баримтыг бөөн дүнгээр бүртгэсэн худалдан авалт хийхгүй байх тухай нийт 3 зөвлөмж хүргүүлэхээр тус тус шийдвэрлэв.

Тав.Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж:


Шалгалтын явцад тус байгууллагын дарга, нягтлан бодогч, шалгалтаар илэрсэн зөрчилд хамаарал бүхий холбогдох албан хаагчтай уулзаж асуулга, тодруулга авч Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулсан болно.

Шалгалтаар илэрсэн зөрчилт үйлдлүүд нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл болох тул холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг ханган ажиллах шаардлагатай байгааг тус сумын ИТХ-ын дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга, нягтлан бодогч, бусад холбогдох ажилтнуудад танилцуулж, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа.



Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулж 2,612.1 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлсэн болно.

Шалгалтын тэмдэглэлд тусгагдсан үүрэг даалгаврын биелэлтийг ханган ажиллах, зөрчлийг арилгасан тухайгаа 2024 оны 09 дүгээр сарын 25-ны дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд албан бичгээр мэдэгдэхийг тус сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга, нягтлан бодогч нарт хариуцуулав.

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД
АУДИТЫН АЛБАНЫ ДОТООД
АУДИТОР  Х.БАТБААТАР

ТАНИЛЦСАН:

САНТ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
 О.МӨНХЦЭЦЭГ
НЯГТЛАН БОДОГЧ
 Ч.МӨНХЗАЯА

